

**УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ  
БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН  
ТӨСЛҮҮДИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨРИЙН  
БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 06 дугаар  
сарын 28-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын даргын 2023 оны 99, 102 дугаар захирамжаар Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгээр ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэн, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Г.Ганболд, Т.Доржханд, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, О.Цогтгэрэл, Т.Энхтүвшин нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан болно.

Байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Ажлын хэсэг Улсын Их Хурлын “d.parliament.mn” цахим системд иргэдээс ирүүлсэн 52 санал, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэн, Ж.Батжаргал, Т.Доржханд, С.Ганбаатар, Ц.Мөнхцэцэг нараас ирүүлсэн 63 санал, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс ирүүлсэн саналууд, мөн 2023 оны 6 дугаар сарын 19-ний өдөр улс төрийн 30 намын төлөөлөл оролцсон хуулийн төслийн хэлэлцүүлгээс гарсан саналуудыг үндэслэн намын бүртгэлтэй холбоотой асуудлыг Сонгуулийн төв байгууллага нягтлахаар байсныг Улсын дээд шүүх бүрэн хариуцах, бүртгэлтэй холбоотой журмыг батлах, намын хатуу гишүүнчлэлийн асуудлыг сулруулах зорилгоор нам нь гишүүд, дэмжигчтэй байхаар, нам бүх шатны сонгуульд намаас нэр дэвшигчийг сонгон шалгаруулах хороотой байх, намд олгох төрийн санхүүжилтийн 2 хувийн босгыг 1 хувь болгож бууруулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Аудитын тухай хуультай нэр томъёог нийцүүлэх зэрэг зарчмын зөрүүтэй 61, найруулгын шинжтэй 2 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.


Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, М.Оюунчимэг нар хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёололтой холбогдуулан асуулт асууж, хариулт авсан.

Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцсэн бөгөөд олонхын санал авсан зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**  **Н.ЭНХБОЛД**

